



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 14,724,470.16 /арван дөрвөн сая долоон зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун далан төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийн балансын үнэ, 11,258,084.43 /арван нэгэн сая хоёр зуун тавин найман мянга наян дөрвөн төгрөг дөчин гурван мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгийн Захиргаа, санхүү эрхэлсэн дэд захирал Д.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт



Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хуандай авантенд, 99-14 УБМ, арал № КМНДТ4ІВВАU835966	2009/2016	14,724,470.16	11,258,084.43	3,466,385.73
	Нийт дүн		14,724,470.16 /арван дөрвөн сая долоон зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун далан төгрөг арван зургаан мөнгө/	11,258,084.43 /арван нэгэн сая хоёр зуун тавин найман мянга наян дөрвөн төгрөг дөчин гурван мөнгө/	3,466,385.73